


Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26 ны өдрийн 3/312 дугаар албан бичгийн хавсралт



**НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН
СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
(2023 он)**

2023 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
1	2	3		5	6	7
ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХИЖҮҮЛЭХ						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	35	32	Zасгийн газрын тохируулагч агентлаг – Биеийн тамир, спортын газраас 2023 оны 04 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Удирдлагын академид зохион байгуулсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын сургалтад Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 5 мэргэжилтэн хамрагдсан. Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хүний нөөцийн хөгжлийн төв, Нийслэлийн Архивын газар, зэрэг 10 гаруй байгууллагаас зохион байгуулсан танхим-17, цахим-15 нийт 50 удаагийн сургалтад давхардсан тоогоор 200 гаруй албан хаагчдыг хамруулсан байна.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	1	-	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц танхим, цахим хосолсон сургалтад мэргэжилтэн М.Цогзолмаа (№A3663), Төрийн албанд анх томилогдсон төрийн албан хаагчийг мэргэшүүлэх богино хугацааны танхим, цахим хосолсон сургалтад мэргэжилтэн Б.Оюунтуяа (№И1031) дугаартай
			Мэргэшүүлэх сургалт	3	4	
			Туршлага солилцох арга хэмжээ	1	1	
		Үүнээс	Бусад	20	20	
			Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	100	100	
			Эмэгтэй албан хаагч	39	39	
			Эрэгтэй албан хаагч	56	56	
			Удирдах албан тушаалтан	3	3	
			Гүйцэтгэх, туслах	97	99	

3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	1,620,0	1,870,0	Удирдлагын академиас 2023 оны 03 дугаар сараас 2023 оны 06 дугаар сарын хооронд зохион байгуулж байгаа ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад суралцаж байгаа 1 албан хаагчийн сургалтын төлбөр 1,620,0 мянган төгрөг, Төрийн албананд анх томилогдсон албан хаагчдад зориулсан анхан шатны 40 цагийн чиглүүлэх сургалтад 2023 оны 04 дүгээр сарын 03-14-ний өдрүүдэд хамрагдаж төгссөн 1 албан хаагчийн сургалтын төлбөр 250,0 төгрөг нийт 2 албан хаагчийн 1,870,0 мянган төгрөгийг байгууллагын сургалт үйлдвэрлэлийн зардлаас гаргаж шийдвэрлэсэн. Хэрэгжилт-100
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	-	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын албан хаагчид тогтвортой суурьшилтай ажиллаж байгаа бөгөөд тухайн байгууллагадаа 3-аас дээш жил ажилласан албан хаагчид ажиллаж байна. 2 албан хаагчийг дотооддоо мерит зарчмаар шилжүүлэн ажиллуулсан. Хэрэгжилт-100
АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	80%	80%	Байгууллагын жилийн төсвийн 80 хувийг албан хаагчдын цалин, шагнал, урамшууллын зардал эзэлж байна. 2023 онд цалинд нийтдээ 173,972,740 төгрөг зарцуулсан. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр үнэлж дүгнэн А, В үнэлэгдсэн албан хаагчдад урамшуулал 12,735,247 төгрөгийг зарцуулсан байна. Хэрэгжилт-100
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	8000	8000	2023 оны 01 дүгээр сарын 02-ны байгууллагын даргын А/01 тушаалаар албан хаагчийн нэг өдрийн хоолны зардал 7000, унааны зардалд 1000 төгрөгөөр тогтоож сар бүр олгож байгаа бөгөөд нийт 10 албан хаагчдад жилийн эцсийн байдлаар 20,080,0 сая төгрөгийг зарцуулсан байна. Хэрэгжилт-100

5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчин сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80 - аас дээш	90 хувь	Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт 10 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаанд 9 албан хаагч буюу дарга-1, хэлтсийн дарга-1, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-5 хамрагдсанас 72 асуулгаар авсан бөгөөд үр дүн нь Нийслэлийн биеийн тамир, спортын газрын албан хаагчид байгууллагын удирдлага, хэлтсийн дарга нарын удирдахуйн ухаанд сэтгэл ханамжтай, ажилдаа дуртай ч ажиллах нөхцөл боломж, дутмаг, ажлын ачаалал ихтэй болох нь судалгаагаар гарсан. Хэрэгжилт-100
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (жилд)	1 - ээс дээш	IV улирал	"Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтийн өдөр Анаагаахын ШУИС-иас ясны сийрэгжилт тодорхойлох аппаратаар 10 албан хаагчдын ясны сийрэгжилтийг тодорхойлуулсан бөгөөд Денк пармын герман Д витаминаар албан хаагчдын жилийн хэрэгцээг хангаж ажилласан. Хэрэгжилт-100
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90 - ээс дээш	90%	Нийт 10 албан хаагчдын ясны сийрэгжилтийг тодорхойлуулсан бөгөөд Денк пармын герман Д витаминаар албан хаагчдын жилийн хэрэгцээг хангаж ажилласан. Хэрэгжилт-100
7.	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	85,055, 460	Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" А/511 дүгээр захирамж, байгууллагын даргын 2023 оны Б/17 дугаар тушаалаар 1 албан хаагч дэс түшмэл дөтгөөр зэрэг, 2 албан хаагч дэс түшмэл гутгаар зэргийн нэмэгдлийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгосон. Хөдөлмөрийн дотоод журмын 6.16.5-д зааснаар Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Батсуурийн Оюунтуяагийн ар гэрийн гачигдалд зориулж, 300,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. Гэр хороололд амьдардаг 2 албан хаагчдад түлээ нүүрсний мөнгө болох 200,000 төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламжийн сангаас олгуулсан. Байгууллагын даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн "Уралдаан тэмцээнд оролцуулах тухай" Б/11 дүгээр тушаалаар Бүгд Найрамдах Солонгос улсын Жонбук хотноо 2023 оны 05


						дугаар сарын 08-24-ний өдрүүдэд зохион байгуулсан Ази Номхон далайн орнуудын Мастеруудын наадмын сагсан бөмбөгийн тэмцээнд Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн дарга С.Саранцэцэгийг багийн ахлагч, тамирчнаар оролцуулахад шаардагдах 7,055,460 төгрөгийг байгууллагын томилолт, уралдаан тэмцээний зардлаас гаргаж шийдвэрлэсэн. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 10 албан хаагчдад иж бүрэн компьютер, өнгөт принтер-1, ширээ, сандал, кофе чанагч- 1, хөргөгч-1 зэрэг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангасан. Мөн олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд 1,200,000 төгрөгийн бэлгэ дурсгалын зүйл гардуулсан.
--	--	--	--	--	--	---

Хэрэгжилт-100

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Ж.ГАНБОЛД

М.ЦОГЗОЛМАА

Б.ОЮУНТУЯА